



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 4 сарын 24 өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

┌ Салбар нээх зөвшөөрөл олгож, бүртгэх тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.2.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Номин даатгал” ХХК-д Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4 дүгээр хороо, Зүүн дөрвөн зам, “Оршил” хотхон, “Номин хайпермаркет”-ын 2 дугаар давхрын байранд салбар нээх зөвшөөрөл олгож, бүртгэсүгэй.

2. Салбар нээх зөвшөөрөл олгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Номин даатгал” ХХК /И.Галбуян/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН